

НОМЫН ШҮҮМЖ

**АМЕРИКИЙН ТҮҮХЧ
Т. АЛСЕНИИ «МОНГОЛЫН
ИМПЕРИАЛИЗМ» ЗОХИОЛЫН
ТУХАЙ ШҮҮМЖ**

(Үргэлжлэл)

Ш. Сандаг

Америкийн эрдэмтэн Алсений «Монголын империализм» зохиолд бидний өмнө өгүүлснийг үргэлжлэн тэмдэглэвэл, Мөнх хааны хүн чанарын тухай нэлээд анхаарал тавьж судалсан байна.

Ер нь хуучин хүнд суртлын аппарат ноёрхож, ганц нэг хүнийг шүтэж байх үеийн хор уршгаас болж түүхийг эзэнгүйдүүлэх, түүхт үйл явдлыг нуршин тоочих Сталин-Брежнев, Чойбалсан-Цэдэнбалын буруу хазгай хэлсэн зүйлийг магтан иш татах, урьдын феодалын нийгмийн түүхийг авч үзэхдээ феодалуудыг нэлэнхүйд муулах, хүний нь хувьд ямар үзэл бодолтой, ямар байр суурьтай, зан төрөхөөр ямар болохыг авч үзэхгүй, нэг үгээр хэлэхэд, түүхийг мушгин гуйвуулж завхаруулж байсан байна. Гэтэл капиталист орны түүхчид болохоор хэдийгээр нийгмийн хөгжлийн зүй тогтолын талаар бидэнтэй ихээхэн зөрөөтэй байдаг ч гэсэн түүхийн үйл явцыг биднээс илүү нарийвчлан бодитой судалдаг байхыг үгүйсгэх аргагүй.

Үүнийг Алсений дээрх номоос тодорхой мэдэж болох байна.

Бодвоос, түүх бол эзэнгүй үйл явдлуудын хэлхээс бус, өөрийн зүй тогтолтойгоос гадна түүх бүтээгч олон түмэн, тодорч гарсан удирдагчдын үйл ажиллагаа, зан чанартай нягт уялдаатай билээ.

Америкийн түүхчийн бичсэнээр, Мөнх хаан их нарийн нямбай, холын бодолтой, улс төрийн бодлогод хянуур ханддаг, овсгоотой хүн байжээ. Гүег хаан дайтаж байлдаж явснаа 1241 онд Монголдоо буцахад нь түүнийг Мөнх дагалдаж, Монголын их хаад өөрчлөгдсөн нөхцөлд түүний гэр бүлийн эрх ашгийг хамгаалж байхаар томилогдсон ажээ. Гүегийн хаан болоход Мөнх болон түүний гэр бүл шинэ хааныг төдийлөн сайн дэмжээгүй ч гэсэн, тэр шийдвэрийг гуйвалтгүй дэмжиж, хаан эзний гаргасан зарлигийг үг дуугүй биелүүлж байжээ. Гүег хаанд Мөнх сайн байхын зэрэгцээ тэрхүү их хааны заналт дайсан Баттай бас дотно үлдэхийг хичээх бөлгөө. Мөнх нь Батын улам доройтсоор буй эрүүл мэндийг байнга асууж, боллоцоотой цагтаа очиж уулзаж билээ. (29-р тал)

Хувь хүний хувьд Мөнх өмнөх хаан Гүегээс огт өөр байжээ. Гүег хэтэрхий үрэмтгий, салан задгай байсан ахул Мөнх их нарийн арвич хямгач, цаг хоосон нөгчөөх, илүү дутуу юманд дургүй хүн нэг л юм илүү хийсэн гэх нь их ордныхоо хаалганы өмнө дөрвөн зүйл сархад гуйх асар том оргилуудыг Парисын уран дархан Баучераар бүтээлгэснийг л хэлж болно. Ер нь Мөнх анхнаасаа хатуу ширүүн зан төрхтэй, аливаа ажлыг нугалж авахыг эрмэлздэг, үл ялих юм гэж анхаарахгүй өнгөрдөггүй хүн байжээ. Өмнөө тавигдсан алив зорилгыг тэр нь ав хоморгонд явах, улсаа жолоодох, дайтах байлдах, эсгүл сархад барих алин боловч ажил хэргийг сайтар бодож тунгаана. Доорхи хүмүүстэйгээ харилцахдаа шаардлагатай, хэлэх шүүмжлэх дуртай, ал

даа эндэгдлийг үл тэвчдэг, магтуулах сайшаалгахыг үл таалдаг байжээ. (29-р тал). Нэг өдөр Мөнх хаан доордостоо зарлиг буулгаж, хэрэв та нарыг магтсан зарлигийг гаргалаа гэж бодоход, та нар эрх ямбанд дурлаж, захирагдахаа болино. Хэрэв та нар эрх ямбанд дурлаж, захирагдахаа байвал та нарыг самуурахгүй гэх аргагүй гэжээ.

Алсен хэрхэн Мөнх хаан сөрөг хүчнүүдийг дарж байсныг хөндөн бичихдээ тэрээр хаан болмогц сөрөг хүчнээс ангижрах анхны зарлиг гаргажээ. Мөнх өөрийг нь хорлох гэсэн хуйвалдааныг илрүүлбэл хэнийг нь ч алдахгүй барьж авахын тулд Монголдоо ч, Зүүн гар Төв азид тусгай цэргийн анги явуулж баривчлуулж байжээ. (31-р тал). Мөнх өөрийн нь эсрэг хуйвалдсан түшмэдийг өөрөө шүүх боловч, нэг их хатуу шийтгэдэггүй байжээ. Жишээ нь Ширээмүн, Бүри хоёрыг цөлөх төдийхөн өнгөрөөжээ. Эзэн хааны ураг төрлийнхнөөс хэрэг хийсэн түшмэд, түүний дотор төрсөн хөвгүүд, тэдний эхнэр, эхчүүлийг мөн адил шийтгэж цөлдөг ажээ. (32-р тал).

Хаан эзэн ураг төрлийнхөө түшмэдээс шүүж байхад, хэрэгт татагдсан бусад иргэдийг өөр газар гэсгээн цээрлүүлнэ. Үүнийг эзэнт гүрний их заргучи Мэнгэсэр гүйцэтгэдэг ажээ.

Шүүлгэ байцаалт зөвхөн Монголд явагддаг төдийгүй, тусгайлан шүүх таслагчдыг Хятад, Төв Азиар илгээж, орон нутгийн цэргийн анги, засаг захиргаанаас гэмтнийг хайн олж шийтгэдэг журам мөрдөгдөж билээ. Монголын их хаан алс холын Ирак хүртэл ч шүүх цаазын түшмэлүүдээ явуулж, шинэ хааны засагт тэрслэгсдийг Мөнх хааны өөрийн нь сонгосон хүмүүсээр халж сольж байжээ. (32—33-р тал). Тэрслэгсдийг цэвэрлэх явдалд эзлэгдсэн орнуудын эрх баригчид өртөгдөх нь цөөнгүй. Рашид-ад-Дина мэдээлснээр засаг захиргааны түшмэд, цэргийн эрх баригчид 77 хүнийг Монголд цаазалжээ. Монголын эзэнт гүрний харьяа өөр бусад орнуудаар гэсгэгдсэн, хоригдсон, цаазлагдсан хүн их олон болжээ. Мөнх хааны өөрийн дотнын зөвлөхүүдээс нийтийн цэвэрлэгээнд өртөгдөлгүй үлдсэн нь цөөхөн ажээ. (34-р тал).

Ингэж Монголын эзэнт гүрний их хаан Мөнх төр улсаа төвхнүүлж байхын тулд авч байсан олон арга хэмжээнүүдийн нэг нь гэсгээн цээрлүүлэх явдал байсан билээ. Чухамхүү ийм арга эс хэрэглэвэл тэр дээр үед төрийн жолоо алдахад хүрэх байсныг дурдахын хамт эцсийн эцэст ямар ч хатуу харгис засаг явуулавч олон жижиг улсуудад хуваагдсан Монголын эзэнт гүрэн мөхөх тавилангаас зайлсангүй.

Сэтгүүлийн үүний өмнөх дугаарт монголын хаад Хятад, Орост хүн амын тооллого явуулж байсан тухай цухас өгүүлсэн билээ. Одоо Иранд хүн амын тооллого явуулсан талаар Т. Алсен бичсэнийг дурдвал Мөнх хааны хаанчлалаас эхлэн Иранд урьдахаас өргөн хэмжээгээр хүн амын тооллого хийх болжээ. Гүржийн он тооллын бичигт тэмдэглэснээр Ираны хүн ардыг Батын зарлигаар тооллосон гэх боловч өөр сурвалж бичгээс үзвэл их хаан Мөнх л хариуцан хийлгэсэн ажээ. Гүржийн сурвалж бичигт ингэж алдаж бичсэний учир нь Гүржийн хаан Мөнхийн явуулсан бичээч түшмэдтэй маргалдахдаа Батын дэмжлэг авах гэснээр тайлбарлагдана. (131-р тал). Перс, Армяны он дарааллын бичгүүдээс үзвэл Мөнх хаан удирдан Иранд хүн амын тооллого явуулсан нь илт ажээ. Ер нь Баруун Азид 1252 оноос эхлэн явуулсан хүн амын тооллогыг Аргун ерөнхийд нь удирдаж байжээ. Монгол ноён Аргун ба түүний бараа бологсод Монголоос гарч явсаар 1253 оны сүүлчээр Харасан хүрч даруй тооллогынхоо ажил эхэлсэн билээ. Аргуны туслагчаар бас хоёр монгол түшмэл очсон нь Наймадай, Гүрүмтэй хоёр ажээ. Зохиогч үүнтэй холбогдуулан бас нэг сонирхолтой ба-

римт дурдсан нь Аргун ноён тооллого дуусгаад 1256-57 онд Монголын нийслэл Хархориндоо буцаж ирээд, түүнийг мөнгө хөрөнгө шамшигдуулав гэсэн зэмлэлийг амжилттай няцааж, 1258 онд Баруун Ази руу буцсан гэдэг. Тэнд очоод Ираны тохинуулах сайд Хулагуутай уулзан, Гүржийн хүн амын тооллогыг дуусгахаар явжээ. (133-р тал). Хүн амын тооллогод монголчуудаас гадна лалын шашинтнуудыг дайчилж тооллогыг орон нутгийн хэрэгцээнд зориулан нутгийн хэлээр, бас Монголын эзэн хаадад толилуулахын тулд монгол хэлээр тус тус хийдэг байжээ. (134-р тал)

Харийн орнуудын харьяа хаад ноёдыг монголын их эзэн хаад хэрхэн тогтоон барьж байсан тухай америкийн түүхчин бичихдээ ураг төрлийн гаралтай түшмэдээс гадна Мөнх хаан эзлэгдсэн харьяа орнуудын эрх баригчдыг захирч, хамтран ажиллаж байхын тулд харилцааны тусгай журамтай байлаа. Монголын эзэнт гүрний хүн амын хамаг ихэнх болох суурин иргэдийг их хаан өөрөө буюу өөрийн тохинуулах түшмэдээр дамжуулан шуудаар юм уу, мөн тухай тухайн харьяат орнуудын эрх баригчдаар дамжуулан шууд бус захирч билээ. Чингэхдээ тэрхүү эрх баригчдад Монголын эзэнт гүрний эрх олгосон тусгай пайз олгоно. (63-р тал)

Америкийн түүхчин Томас Алсений «Монголын империализм» зохиолын шүүмжийг үүгээр хязгаарлаж, өгүүлэхэд энэхүү ном гүн гүнзгий судалгаанд үндэслэн бодит баримтад түшиглэн бичсэн эрдэм шинжилгээний дорвитой сайн бүтээл мөн болохыг тэмдэглэмээр байна.

Олон уншигчид, Монголын түүх сонирхогчдод зориулан Т. Алсений энэхүү зохиолоос зарим бүлэг ангиудыг орчуулан эрдэм шинжилгээний сэтгүүлүүдэд хэвлэх нь зүйтэй шиг санагдана.

Эцэст нэг санал хэлэхэд Монголын их хаадын тухай түүх шастир гадаад орнуудад хэвлэгдэн гарсаар он уджээ. Одоо ч энэ хэзээ ч сонирхол үл буурах сэдвээр гадаадын түүхчид шинжилгээ судалгаа хийсээр байгааг АНУ-ын Трентон хотын улсын коллежийн түүхчин профессор Томас Алсений бүтээл тод харуулж байна.

Харин манай монголын түүхчид урьдын хүнд суртлын захиран тушаах аппарат, ганц нэг хүнийг тахин шүтэх явдлаас болж, богд Чингис хаанаас эхлэн Монгол их хаадын түүх намтар үйл ажиллагааны тухай бичих байтугай, нэрийг нь ч хэлж болохгүй явсан цаг сая хүртэл байсан шүү дээ.

Одоо өөрчлөн байгуулалтын ариутган цэвэрлэх салхи нийгмийн ухаанд ч нөлөөлж, түүхчин бид биеэ дааж, өөрийн гэх ухаан бодолтойгоор эх орныхоо өнгөрсөн, одоо, ирээдүйгээ гярхай нүдээр харж, үнэн зөвөөр бүтээлээ туурвих сайхан бололцоотой болжээ.

Монголын их хаадын тухай Монголд нь ном зохиол гарахгүй ирсэн явдал тун харамсалтай хэрэг биш үү.

Иймд Монголын их хаадын тухай олон сайхан ном зохиол ундран гарах байх гэж найдна.